



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/19

Чойбалсан

Коронавируст халдварын үеийн өдөр тутам
болон нөөцийн бүртгэл мэдээллийг
сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, 12.1.4, 13.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаал, 2021 оны 01 дүгээр албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1.Коронавируст халдварын цар тахлын үеийн бүртгэл, мэдээлийн бэлэн байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, бүртгэлийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Тушаалыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн тайланг заалт бүрээр, сар бүрийн 30-ны дотор Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлэхийг Эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч. ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргыноны
0.5.. дугаар сарын 13...ны/ний өдрийн
#19... дугаар/дүгээр тушаалын
хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕИЙН ӨДӨР ТУТАМ БОЛОН НӨӨЦИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Эрүүл мэндийн байгууллагууд нь Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуурын орлого, зарлагын мэдээллийг burtgel.mohs.mn цахим системд өдөр бүр шивж оруулах.

2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын илрүүлэх ПГУ шинжилгээний бүртгэл, лабораторийн үйл явц, эргэн мэдээллийг eguul.gerege.mn, тандалт, орны тоон мэдээ, тусгаарлан ажиглах байрны үйлчлүүлэгчийн орны мэдээг tandalt.gov.mn цахим системүүдэд оруулж мэдээллийн санг үүсгэх.

3. Коронавируст халдварын дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн мэдээллийг тухай бүр health.gov.mn цахим системд оруулж, мэдээллийн санг үүсгэх.

4. Дархлаажуулалтын мэдээний чанар, үнэн зөв байдалд дархлаажуулалтын эмч хяналт тавих, дархлаажуулалтын бүртгэлийн ажилтныг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.

5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний мэдээллийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалаар батлагдсан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ” АМ-36 маягтаар мэдээлж, мэдээллийг burtgel.mohs.mn цахим системд шивж оруулах.

6. Коронавируст халдвар /КОВИД-19/-аар хэвтэн эмчлүүлэгч, гэрийн тусгаарлалтын эмчлүүлэгч, нас баралтын мэдээллийг тухай бүр эрүүл мэндийн статистикийн боловсруулалтын H-info цахим системд оруулж, мэдээллийн сан үүсгэх.

7. Коронавируст халдвар /КОВИД-19/-аар хэвтэн эмчлүүлсэн тухай эмнэлгийн магадлагааг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалаар батлагдсан “Эмнэлгийн магадлагаа” АМ-8 маягтаар олгох бөгөөд H-info цахим системд мэдээллийн сан үүсгэх.

8. Мэдээний чанар, үнэн зөв байдалд эрүүл мэндийн байгууллагын удирдлага тогтмол хяналт тавих.

9. Цахим системийн хэвийн үйл ажиллагааг Эрүүл мэндийн газрын мэдээллийн технологийн мэргэжилтэн хариуцан ажиллах.